

Хүн ам ба нөхөн үржихүй

Н. Гэрэлсүрэн

Монголын Эмэгтэйчүүдийн

Холбооны Ерөнхийлөгч

Хүн ам ба хөгжилд нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудал чухал байр суурь эзэлнэ. Нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудал нь өргөн утгаараа хүн төрөлхтөний оршин тогтнох бүхий л харилцааны агуулгыг өөртөө багтаадаг учир ямагт дэлхий нийтийн анхаарлын төвд байсан, одоо ч байсаар байна. Ялангуяа хүн төвтэй хөгжлийн эрин зуун эхэлж байгаа өнөө үед энэ асуудлын ач холбогдол улам бүр өсөх нь дамжиггүй. Үүний нэг тод илрэл бол сүүлийн жилүүдэд хүн ам ба хөгжлийн асуудлаар дэлхийн хэмжээнд зохион байгуулагдсан хурлуудад нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудалд анхаарч гарсан шийдвэрүүддээ тодорхой заалтуудыг тусгасан явдал юм. 1992 оны Рио де Жанейрогийн "Байгаль орчин хөгжил" НҮБ-ын бага хурлаар хэлэлцэн сайшаасан "Даян дэлхийн 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-ийн "хүн амын эрүүл мэндийг хамгаалах", "тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн үүрэг харицлага" гэсэн бүлгүүдэд нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудлаар авах арга хэмжээг тодорхой заасан билээ. Дэлхийн 180 улс оролцсон 1994 оны "Хүн ам ба Хөгжил" Олон улсын бага хурлаас нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, үйлчилгээг 2015 он гэхэд бүх нийтийг хамарсан мэдээлэл үйлчилгээний цогц түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлсэн юм. Каирын бага хурлаас хойш НҮБ-ын Хүн Амын Сангаас "Дэлхийн хүн амын байдал" 3-р илтгэлийг гаргав. Энэ илтгэлд бэлгийн харилцаа, нөхөн үржихүйн эрхийн салбарт гарч буй ахиц дэвшил, тулгамдсан асуудлыг тусган оруулжээ. Мөн 1995 онд Бээжин хотноо болсон дэлхийн эмэгтэйчүүдийн 4-р бага хурлаас гаргасан тунхаглалын "Эмэгтэйчүүд ба Эрүүл мэнд" гэсэн бүлэгт нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн тухай ойлголтыг өгч улмаар уг асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагаас авбал зохих арга хэмжээг тодорхой заасан юм. Манай улсын төр засгийн тэргүүн болон төлөөлөгчид эдгээр хурлуудад оролцож байсан ба нөхөн үржихүйн асуудалд анхаарч багагүй арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн Газар 1996 онд "Эмэгтэйчүүд-нийгмийн хөгжилд" үндэсний чуулганыг санаачлан зохион байгуулж "Монголын эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах" үндэсний хөтөлбөрийг хэлэлцэн зөвшилцөж улмаар засгийн газрын хурлаар баталсан юм. Энэ хөтөлбөрт "Эмэгтэйчүүд ба нөхөн үржихүйн эрүүл мэнд" гэсэн тусгай бүлгийг оруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн ЭМНХЯ-наас НҮБ-ын Хүн Амын Сангийн тусламжтайгаар хүн ам зүйн асуудлаар олон төсөл хэрэгжүүлж байгаагийн нэг хэсэг нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн багц төслүүд юм. Эдгээр төслийн хүрээнд гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуй, өсвөр үеийг гэр бүлд бэлтгэх, тэдний эрүүл мэнд сэдвээр иргэдийн дунд сургалт сурталчилгаа, явуулах, мэдээлэл өгөх, эрүүл мэндийн төв болон эхчүүдийн амрах байрыг тохижуулах, жирэмслэлтээс сэргийлэх хэрэгсэл, эмийг үнэ төлбөргүй тараах зэрэг арга хэмжээ авсан нь зохих үр дүнгээ өгч байна. ЭМНХЯ, МЭХ, НҮБ-ын хүн амын сан хамтран "Эхэд ээлтэй эмнэлэг" шалгаруулах болзол гарган ажиллаж байна. Энэ болзлоор 1997 онд Хөвсгөл аймгийн Шинэ идэр сумын эмнэлэг шалгарч "ЭХО" аппарат, "Эхэд

ээлтэй эмнэлэг" хаягаар шагнагдсан юм. Мөн 1996 онд ЭМНХЯ, МЭХ хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн тусламжтайгаар бүх аймгийн 100 сумын эхчүүдийн амрах байрыг тохижуулах тусламж, 1997 оны сүүлчээр НҮБ-ын Хүүхдийн Сангаас ирүүлсэн хөрөнгийг Архангай, Сэлэнгэ, Баян-Өлгий аймгийн 10 суманд нөхөн үржихүйн зөвлөгөө өгөх, танхим, эхчүүдийн амрах байрыг тохижуулах, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулахад зориулан газар дээр нь хүргэж өгч, зөвлөмж өгөх ажлыг зохион байгууллаа.

Эрэгтэй, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээний адил тэгш боломж нөхцөл бүрдүүлэх, эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад төрөөс онцгой анхаарах асуудлыг манай улс үндэсний хууль тогтоомжоороо баталгаажуулан, олон талын арга хэмжээг хэрэгжүүлж ирсний дүнд үйлчилгээний дэд бүтэц нэлээд сайн хөгжиж хүн амын, түүний дотор эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар багагүй амжилт олсон билээ. Өнөөгийн байдлаар хүүхэд, жирэмсэн болон нярай хүүхдээ асарч байгаа эхчүүд, тахир дутуу, ахмад насны иргэдийн эрүүл мэндийн даатгалыг төр хариуцаж, үндсэндээ эмнэлэгийн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжирсаар байгаа ч эх, нялхасын эндэгдэл дорвитой буурч чадахгүй байх, ялангуяа сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд таагүй нөлөөлөх бэлгийн замаар халдварладаг өвчнүүд нэмэгдэх, гэр бүл төлөвлөлтийн арга хэмжээ нь гэр бүлийн хос, эмэгтэйчүүдийн амьдралын хэрэгцээ болж чадаагүйгээс эмэгтэйчүүд хүсээгүй үедээ жирэмсэлж, үр хөндүүлэх явдал ихэсч байна.

Нөхөн үржихүйн эрх, эрүүл мэнд гэдэг нь бүхэл бүтэн хоёр том бүлэг асуудал яригдаж байгааг хүн бүхэн мэдэрдэг боловч энэ асуудлын сургалт сурталчилгаанд эрүүл мэндийн асуудал нь илүү яригдаж эрхийн тухай асуудал бага яригдаж байна. Тиймээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хүн бүрт нөхөн үржихүйн эрхийг ойлгуулах явдал чухал. Зарим хүмүүстэй нөхөн үржихүйн асуудлаар санал солилцоход энэ нь зөвхөн эмэгтэйчүүдтэй холбоотой, жирэмслэлт, үр хөндүүлэх асуудал мэт дутуу ойлгосон тохиолдол нэлээд байдаг. Тэр ч битгий хэл нэг үе эрүүл эхээс эрүүл хүүхэд төрнө гэсэн уриа ч байсан. Энэ нь хүний нөхөн үржихүйн асуудал бол зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал гэсэн ойлголтыг ч төрүүлж болох талтай юм. Тийм ч учраас нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг гол төлөв эмэгтэйчүүдийн дунд явуулж байсан байж болох талтай. Магадгүй ийм өрөөсгөл ойлголт нь хүсээгүй жирэмслэлт дорвитой буурахгүй байх, үр хөндөлт, үргүйдэл, эрт төрөлт, эмэгтэйчүүдийн өвчлөл дорвитой буурч чадахгүй байгаад нөлөөлж ч байж болох юм. Ийнхүү нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн арга хэмжээг цогц болгон сайжруулахад тулгамдсан асуудал цөөнгүй байгаа юм.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг нь зөвхөн нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эрүүл мэндийн асуудал биш. Харин бие бялдар, оюун ухаан, нийгмийн талаар бүрэн төгс эсэн мэнд байхыг хэлнэ.

Нөхөн үржихүйн эрх нь хүний эрхийн талаархи олон улсын баримт бичгүүд болон олон улсын зөвшлүүдэд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн зарим

эрхийг агуулж байгаа юм. Гэр бүл бологчид болон хувь хүн хүүхдийнхээ тоог, тэднийг төрүүлэх хугацаа цагийг чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдэх, энэ талаар мэдээлэл авах, нөхөн үржихүйн эрүүл ахуйн хамгийн дээд стандартад хүрсэн үйлчилгээ авах, түүнчлэн хүний эрхийн тухай баримт бичгүүдэд заасанчилан аливаа хувь хүн нөхөн үржихүйн эрүүл ахуйн талаар гадуурхал, албадлага, хүчирхийллээс чөлөөтэйгээр шийдвэр гаргах зэрэг нь нөхөн үржихүйн эрхийн тулгуур эрх мөн. Энэ бүхнээс үзэхэд нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүний аль алинд нь хамааралтай асуудал мөн тул энэ асуудлаар авах бүх төрлийн арга хэмжээнд эрэгтэй эмэгтэйчүүдийг тэгш оролцуулж байх шаардлага амьдралаас урган гарч байна. Энэ байдалд дүгнэлт хийж нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн талаар иргэдийн мэдлэгийн түвшинд нарийвчилсан судалгаа хийсний үндсэн дээр уг асуудлаар явуулах сурталчилгаа, сургалтыг насны онцлог, мэдлэгийн түвшинд нь тохируулан явуулах нь илүү үр дүнд хүргэнэ.

Бэлгийн харилцаа болон нөхөн үржихүйн эрхийг баталгаажуулах нь өөрөө эцсийн зорилт биш бөгөөд энэ нь нийгэм эдийн засгийн амьдралд нөлөөлөн үндэсний болон дэлхий нийтийн ирээдүйн хөгжилд тусгалаа олдог. Каирын шийдвэрийг хүлээн зөвшөөрснөөр нөхөн үржихүйн эрх, эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж байна. Төрийн бус байгууллагууд нь эмзэг давхаргад түргэн хүрч чаддагаараа уян хатан шинж чанартай байдаг юм. Энэ чанараараа засгийн газрын үйлчилгээг хүргэхэд маш том туслалцаа болдгийг олон улсын ба манай төрийн бус байгууллагуудын туршлага харуулж байна. Манайд ч ийм боломж байна. Жишээ нь Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо 1993–1996 онуудад "Эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлж өрхийн сайн сайхан байдлыг бэхжүүлэх" төслийг НҮБ-ын Хүн Амын Сан, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагуудын туслалцаатайгаар Улаанбаатар хот, Төв, Дорноговь аймгийн суманд хэрэгжүүлсэн юм. Энэ төслийн хүрээнд нэр бүхий газрын 2000 гаруй хүнд гэр бүл төлөвлөлтийн болон эсэн мэнд амаржихуйн сургалт, сурталчилгааг хүргэсэн байна. Үүнээс гадна ДОХ болон бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлаар 3000 шахам хүнд мэдээлэл хүргэсний зэрэгцээ өөрийн сайн дурын багш нарыг ЭМНХЯ-наас явуулсан сургалтад оролцуулан бэлтгэж авсан байна.

Өнөөдөр монголд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн төрийн бус 20 гаруй байгууллагуудаас гадна гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг, мэргэжлийн эмч нарын нийгэмлэг, өрхийн эмч нарын болон залуу эмч нарын холбоо зэрэг нөхөн үржихүйн асуудлаар ажиллах мэдлэг дадлагатай байгууллага олон байна. Иймд тэдний хүчийг ашиглахад засгийн газар анхаарч тэдэнтэй хамтран ажиллах механизмыг зөв тогтоох явдал чухал юм.

Нөхөн үржихүйн эрхийг баталгаажуулахын тулд " Гэр бүлийн тухай" хуулийн төсөлд эмэгтэйчүүдийн байгууллагаас холбогдох байгууллагуудад олон санал дэвшүүлээд байна. Энэ нь манай төрийн бус байгууллагаас иргэдийнхээ нөхөн үржихүйн эрхийг хамгаалах талаар ажиллаж байгаа нэг хэлбэр мөн.

Цаашид нөхөн үржихүйн эрхийн баталгаажилт манай хуулиудад хэрхэн туссан, түүний биелэлт ямар байгаад дүгнэлт хийх, хүн ам, хөгжлийн бодлого боловсруулахад төрийн бус байгууллагын саналыг авах, ялангуяа сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын хүчийг ашиглах өргөн боломж байна.

Ашигласан материал :

1. Дэлхийн хүн амын байдал илтгэл 1997 он НҮБ-ын Хүн Амын Сан
2. Монголын хүн ам зүйн судалгаа 1997 он МУИС, ХАЗССТ
3. Дэлхийн нийгмийн байдал, шинэ зууны хандлага 1998 он Пенсилваны ИхСургуулийн профессор Ричард Эстэсийн илтгэлийн товчлол
4. "Хүн ам ба хөгжил" Олон улсын бага хурлаас гаргасан үйл ажиллагааны хөтөлбөр 1996 он НҮБ-ын Хүн Амын Сан
5. Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр НҮБ 1995 он
6. Монголын эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр 1996 он